



ЗҮЙ ЁС НАМ



# “Хөгжлийн шинэ төв - Дархан” Мөрийн Хөтөлбөр

Дархан-Уул Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2020 оны ээлжит сонгуульд оролцох Зүй ёс намын  
Мөрийн Хөтөлбөр

2020 оны 6 сарын 24



## ОРШИЛ

Зүй Ёс намын 2020 оны Дархан-Уул аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого зэрэгт нийцүүлэн боловсруулсан баримт бичиг болно.

## ХҮНИЙ ХӨГЖИЛ

Хүнээ хөгжүүлэх, мэргэшүүлэх замаар орон нутгийн хөгжилд хөтлөх, бие даасан, хараат бус нийгэм бүтээх хүн төвтэй бодлого хэрэгжүүлнэ. Мэргэжлийн боловсрол болон үндэсний үнэт зүйл, хувь хүний хүмүүжил төлөвшлийн тал дээр онцгой анхаарч хамтын нийгэм бүтээх зорилго тавин ажиллана.

Боловсрол, шинжлэх ухаан, инновац

Цээжилдэг бус бүтээгч иргэнийг бэлтгэдэг боловсролын тогтолцооны суурийг тавина. Үүнээс дараах зорилтуудыг онцолж үзнэ.

- а) Багш нарын ажлын үнэлэмжийг дээшлүүлнэ.
- б) Асуудал шийдвэрлэх сургалтын арга зүйг орон нутгийн сургуулиудад нэвтрүүлнэ.
- в) Орон нутгийн тулгамдсан асуудалд эрдэмтдийн судалгааг чиглүүлнэ.

Хүн бүрт чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, цахим болон зайны сургалтыг ашиглан боловсролын хүртээмжийг сайжруулна.

Мэргэжлийн боловсрол олгох мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, технологийн коллеж, коосэн (технологийн ахлах сургууль)-ийг бодлогоор дэмжиж, чанартай боловсон хүчин бэлдэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Орон нутаг бүрийн онцлог, давуу тал дээр тулгуурласан судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналтыг хийх хараат бус бүтэц үүсгэж урт хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлох нэгж байгуулна.

Зорилтот бүлгүүдийн боловсролын чанар, хүртээмжид онцгой анхаарч, хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн бодлого хэрэгжүүлнэ.

Бурхантын хөндий Монголын Цахиурын хөндий хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлнэ. Үүний тулд


- а) Программ үйлдвэрлэгчдэд татварын таатай орчинг бүрдүүлнэ.
- б) Мэдээллийн технологийн бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийг байгуулна.
- в) Дунд сургуулийн багш, сурагчдад мэдээллийн технологийн хичээлийг сонгон суралцах боломжоор хангана.

Эрүүл мэнд, гэр бүл, Монгол хүний удмын сан

Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хөдөө орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулна.

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулж, чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Эмийн бус эмчилгээ болон нөхөн сэргээх эмчилгээг бодлогоор дэмжиж эрүүл дадал хэвшилтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэхийг зорьж ажиллана.



Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж, аз жаргалтай, бүтээлч, орлоготой гэр бүлийг төлөвшүүлэх бодлого баримтална.

Угийн бичиг хөтлөх, цус ойртолтоос сэргийлэх хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлж, удмын сангийн аюулгүй байдлыг хангана.

**Хөдөлмөрийн зах зээл, ээлтэй амьдрах орчин**

Орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрт тухайн орон нутгийн иргэдийг түлхүү ажиллуулах бүтцийг бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэртэй байдлыг хангана. Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөрийн үнэлэмж, бүтээмж өндөртэй ажлын байруудыг бүрдүүлнэ

Эрүүл, ая тухтай, таатай амьдрах орчныг бүрдүүлж, баталгаат хүнсээр хангах бүтцийг бүрдүүлнэ.

**АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА**

Нийгмийн хамгааллын бодлогыг сайжруулж, нийгмийн болон тэтгэврийн даатгалын шинэчлэл хийж, үр өгөөжийг нэмэгдүүлнэ. Зорилтот бүлгүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн халамжийн бодлого нэвтрүүлнэ. Хүндээ ээлтэй дундаж давхарга ихтэй Дархан-Уул аймгийг бүтээхийн төлөө ажиллана.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалт, хариуцлагын бодлогыг шинэчилж, хамрах хүрээг өргөжүүлж, ипотека, зээлийн сантай холбох замаар үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

Хүн амын бүлгүүдэд тохирсон нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг бүрдүүлж, зорилтот, эмзэг бүлэгт чиглэсэн халамжийн үйлчилгээг сайжруулна.

Биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлж, хөдөлмөр, хүмүүжлийн арга хэрэгслээр дамжуулан эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг төлөвших бүтцийг дэмжинэ.

**Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес, дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт**

Дундаж давхаргыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ажлын байрыг нэмэгдүүлэх асуудалд онцгой анхаарал хандуулж, жижиг, дунд болон бичил бизнесийг дэмжих тогтолцоог бүрдүүлж, өрсөлдөх чадвар, бүтээмжийг нэмэгдүүлэх зөвлөмж, зөвлөгөөний системийг төлөвшүүлнэ.


Малчид, тариаланчдын өрхийн аж ахуй эрхлэх боломжийг нэмэгдүүлж, тогтвортой орлогын эх үүсвэртэй болох бүтэц бүрдүүлнэ.

Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээ болон санхүүгийн мэдлэг олгох үйлчилгээ үзүүлж эрсдэлээс хамгаалах бүтэц бүрдүүлнэ.

**Орлогод нийцсэн орон байр**

Орон нутгийн онцлогт тохирсон, өрх бүрийн орлогод нийцсэн орон сууцыг бодлогоор дэмжиж, ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны чанар, стандартыг тогтооно.

**Газрын харилцаа**



Орон нутгийн иргэдийн газар түлхүү эзэмших боломжийг дэмжиж, газрын харилцаа, менежментийн шинэчлэл хийнэ. Газар, түүний нөөцийг зохистой эзэмших, ашиглах тал дээр тэгш байдлыг хангаж, хамгаалах, нөхөн сэргээх, хяналтын системийг бий болгоно. Газрын хяналтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар шударга ёс, тэгш байдал, үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах бодлого хэрэгжүүлнэ.

## ЭДИЙН ЗАСАГ

Залуучууд нь ажлын байртай, малчид нь тогтвортой, амьдралд хүрэлцэхүйц орлоготой, ахмад настан болон хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон байгаль орчиндоо ээлтэй, ядуурал үгүй, үндэсний онцлог бүхий аялал жуулчлал хөгжсөн, хөгжлийн зөв загвар бүхий олон тулгуурт эдийн засагтай Дархан-Уул аймгийг зорино.

Дархан хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн цогцолбор хот хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнд дараах дэд зорилтууд багтана.

- а) Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, сургалт, судалгааны цогц бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- б) Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн төвийг байгуулна.
- в) Өрхийн хүнсний үйлдвэрлэлийг дэмжсэн сургалтын тогтолцоог бий болгоно.

## САЙН ЗАСАГЛАЛ

Намчирхал, талцал, ялгаварлан гадуурхдаг гажуудлыг залруулж, чадалтай, мэдлэгтэй, хариуцлагатай, ёс суртахуунтай нь орон нутгаа удирдан хөгжүүлдэг тэгш боломжтой, шударга, мэргэшсэн төрийн алба бүхий Дархан-Уул аймгийг зорино. Иргэн төвтэй, сахилга баттай улс төрийн соёлыг Дархан-Уул аймагтаа нэвтрүүлнэ.

### Талцал үгүй Дархан-Уул аймаг

Хөдөө орон нутгийн өөртөө засах эрхийг нэмэгдүүлж, малын хөлийн татвар зэрэг татварыг хөдөө орон нутгийн хөгжилд зарцуулах эрхийг тухайн орон нутагт нь олгох, тухайн бүсийн байгалийн баялгийн нөөцийг ашигласны эцсийн үр өгөөжийг ахиу хүртээх, байгаль орчныг хамгаалах нийтлэг асуудлыг аймаг, сум, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хамтын хүчээр шийдвэрлэж экологийн тэнцвэртэй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Улс төрийн намын харьяалал, нас, хүйс, гарал үүсэл болон өмч хөрөнгийн хэмжээгээр хүнийг ялгаварлан гадуурхдаг явдлыг таслан зогсооно.

### Иргэдийн оролцоотой шийдэл

Аливаа асуудлыг шийдэхэд иргэдийн оролцоог хангаж ажиллана.

Төсөв, санхүүжилт, үйл ажиллагаанд ил тод, нээлттэй, хяналттай байдлыг бий болгож, авлига, ашиг сонирхлын тогтолцоог устгана.

Төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулж, төсвийн гүйцэтгэлд төрийн сангаас тавих хяналт шалгалтыг тогтмолжуулж, төсвийн үргүй зардал гаргахгүй ажиллана.

### Ажлын байртай Дархан-Уул аймаг

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудыг олон нийтийн

нээлттэй санал асуулга явуулан, ИНХурлаар хэлэлцүүлж, сумын ИТХ-д өргөн барих ажлыг хуулийн дагуу гүйцэтгэн, төсөл, хөтөлбөр, төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, зээлийг олон нийтэд ил тод нээлттэй хэлэлцүүлнэ.

Шударга ёсыг бэхжүүлэх, авлигыг устгах чиглэлээр боловсрол, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээг хамарсан цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ. Нийгмийн хөгжил дэвшилд жендерийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх орчныг бүрдүүлнэ.

Хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн ялгааг бууруулах, хөдөлмөрийн зах зээл дээр шинэ боломжийг нээж өгнө.

Эмэгтэйчүүдийн далд дарангуйллыг устгах, хүн худалдаалах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэнэ.

Ёс суртахууны доройтол, архидалт, мансуурал, садар самуун зэрэг нийгмийн гаж үзэгдэлтэй хуулийн хүрээнд тууштай тэмцэж нийгмийг эрүүлжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгааг нь хангана.

## НОГООН ХӨГЖИЛ

Байгалийн баялгийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хөрс, ус, агаарын бохирдлоос сэргийлэх ажилд иргэдийн тавих хяналт, оролцоог нэмэгдүүлнэ.

Байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хуулийн дагуу гүйцэтгүүлнэ.

Аймгийн нутаг дэвсгэрт усны эх үүсвэрийн тооллого явуулж, ус ашиглалтын байдлын түвшнийг тогтоон, усны мэдээллийн санг шинэчлэн байгуулж, усны бохирдлыг багасгана.

Бүх нийтээр мод тарих ажлыг жилд 2 удаа зохион байгуулж, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэн, ААНБ-ийг идэвхтэй оролцуулна.

Засгийн газрын 308 тогтоолоор батлагдсан журмын дагуу Бичил уурхайн чиглэлээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан газруудад нөхөн сэргээлт хийх ажлыг эрчимжүүлнэ.

Байгаль дахь хог хаягдлыг арилгах, түүж цуглуулах тогтолцоог боловсронгуй болгож, аялал жуулчлалын орлогоос хог хаягдлыг бууруулах менежментийг санхүүжүүлнэ.

Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хяналт шалгалтыг тогтмолжуулан хууль бус үйлдлүүдийг таслан зогсооно.

-----oOo-----

